

Экватор [De Evenaar]

Хойд Голландын ёс суртахууны өөрчлөлт ба сэтгэц мэдрэлийн төв

Үйлчлүүлэгчид зориулсан мэдээлэл

Экватор

Ёс суртахууны өөрчлөлт ба Сэтгэц мэдрэлийн Экватор Төв нь сэтгэл мэдрэлийн өвчтэй ба түүнээс гадна ёс заншил зөрөөнөөс болж сэтгэцийн өөрчлөлт орсон болон хүнд зовлон туулж байснаасаа болж сэтгэлийн өвчинд нэрвэгдсэн гадаад улсаас гаралтай хүмүүст сэтгэл зүйн ба сэтгэл мэдрэлийн эмчилгээ хийх ба тусламж үзүүлдэг. Экватор Байлэнд байдаг ба гадаад улсаас гаралтай Хойд Голландад амьдардаг бүх насны хүмүүст тусламж үзүүлдэг. Та энэ мэдээллийн хуудаснаас Экваторт хийгдэж буй эмчилгээний талаар дэлгэрүүлж унших болно.

Экватор хэнд зориулагдсан бэ?

Экватор нь гадаад улсаас гаралтай хүмүүст сэтгэл мэдрэлийн эмчилгээ хийдэг. Экваторын эмчилгээг ерөнхий сэтгэл мэдрэлийн эмчилгээний төрлүүдийг өөр ёс заншил, суртахуунаас гаралтай хүмүүст тохируулан өөрчилж хийдэг.

Ерөнхий сэтгэл мэдрэлийн эмчилгээ нь тэр болгон гадаад улсаас гаралтай хүмүүст тохирдоггүй. Үүнд тэдний ёс суртахуун нь гол шалтгаан болдог. Заримдаа ёс заншилаас үүдсэн зөрөөний орон зайг ойртуулж болдог. Гэхдээ ингэхийн тулд эмчилгээ болон тусламж өгч байгаа эмч нарт илүү цаг хугацаа болон мэдлэг шаардлагатай байдаг.

Түүнээс гадна Экваторт маш аймшигтай юм туулж өнгөрүүлсэн хүмүүст тусгай эмчилгээ хийх мэдлэг туршлагатай эмч нар ажилладаг. Экваторт эмчилгээнд ирж байгаа ихэнх хүмүүс их уйтгар гунигтай байдаг ба муу унтах, бодлогошрох, хар дарж зүүдлэх мөн биеийн олон зовиуртай байдаг. Үүнээс болоод эдгээр хүмүүсийн хэвийн амьдрах нөхцөл нь багасдаг. Олон хүмүүс амьдралаа аваад явах чадваргүй болдог ба амьдралынхаа замыг алдсан юм шиг санагддаг.

Эмчилгээ нь яаж явагддаг вэ?

Таны өрхийн эмч юмуу GGZ Drenthe-ийн эмч таныг Экваторт бүртгүүлнэ. Үүний дараа тантай уулзаж танилцахын тулд таныг урьсан захиа танруу явуулна. Тантай энэ ярилцлагыг сэтгэл мэдрэлийн эмч юмуу сэтгэл зүйч юмуу зарим тохиолдолд эмчилгээний эмч авдаг. Энэ ярилцлагад ар гэрийнхэн тань юмуу таны итгэдэг хүнийг байлцуулахыг бид чухалд үздэг. Шаардлагатай тохиолдолд орчуулагч урьж авчрах болно. Энэ ярилцлагын зорилго нь тантай танилцаж танд ямар өвчин зовиур байгааг мэдэх болно. Энэ ярилцлагаас тулгуурлаад таныг Экваторт эмчлэх нь тохиромжтой юмуу үгүй юмуу гэдгийг гаргаж ирнэ.

Өвчтөн болгонд тусад нь эмчлэх төлөвлөгөө зохиодог. Энэ төлөвлөгөөнд хэн таны үндсэн эмчлэгч эмч болох мөн эмчилгээний зорилго бас та ямар ямар эмчилгээнүүдэд явах нь бичээстэй байдаг.

Экваторт олон төрлийн эмчилгээнүүд байдаг.

Эмнэлэгт хэвтэхгүйгээр эмчлэх эмчилгээ

Эмнэлэгт хэвтэхгүйгээр эмчлэх эмчилгээ нь хувь хүнд тусад нь зориулсан эмчилгээ ба эмчилгээний явцад тантай сэтгэл мэдрэлийн эмч юмуу сэтгэл зүйч юмуу эсвэл сэтгэл мэдрэлийн сувилагч тогтмол ярилцлага явуулж байна. Түүнээс гадна эмчийн заавраар танд эм бичиж өгч болно.

Эмнэлэгт хэвтэхгүйгээр эмчлэх эмчилгээн нь бас хүүхэд болон залуу хүмүүст тусад нь зориулсан байдаг. Хэрвээ нэг гэр бүлийн хэд хэдэн гишүүд сэтгэл санааны шаналгаа зовиур өвчтэй тохиолдолд GGZ Drenthe-ийн гэр бүлд зориулсан эмнэлэгт хамтад нь эмчлэх боломж бий.

Зарим тохиолдолд эмэн эмчилгээ болон ярилцлага эмчилгээ нь таны өвчнийг эдгээхэд хангалттай бус байдаг. Энэ нөхцөлд тантай зөвлөлдөн таныг өөр эмчилгээнд явуулж болдог. Ийм эмчилгээнд голцуу ярих шаардлага байдаггүй ба зөвхөн юм хийх нь чухал байдаг. Ийм эмчилгээг заримдаа тустай хийдэг ба заримдаа хэсэг хүмүүстэй хамтарч хийдэг. Ийм эмчилгээнүүдийн жичээнүүд: мэдрэлд нөлөөлөх биеийн хөдөлгөөний эмчилгээ (хөдлөх), чөлөөт сэтгэн бодох эмчилгээ (зураг зурах юмуу жүжиг тоглох), харилцааны эмчилгээ (гэр бүлийн хүмүүстэйгээ хамт)

Өдрийн эмчилгээ

Өдрийн эмчилгээний хамгийн шургуу хэлбэр нь хоёр өдөр тутмын бүлэгт хамрагдах эмчилгээ юм. Эхний ээлж нь тухайн хүний биеийн байдлыг харах зорилготой наймаас арван долоон хоног үргэлжилдэг. Тэрний дараа эмчилгээний үе эхлэх ба энэ нь эрчүүд болон эмэгтэйчүүдийн хэсэг гэж хуваагддаг. Хөтөлбөр нь хэд хэдэн эмчилгээнээс бүрдэх ба тустай болон бусад хүмүүстэй цуг ярилцдаг. Энэ эмчилгээ дээд тал нь нэг жил үргэлжилж болдог. Энэ хоёр өдөр тутмын бүлэгээс гадна өөр хэдэн бүлгүүд байх ба энэ үргэлжлүүлж эмчлэх эмчилгээнд хамрагддаг.

Үйл ажиллагааны хэлтэс

GGZ Drenthe-д хэд хэдэн өдрийг үр бүтээлтэй өнгөрүүлэх боломжууд байдаг ба Экваторт эмчлүүлж байгаа хүмүүс үүнийг хэрэглэж болно. Жишээ дурдахад Байлэнд нэг ургамлын хүрээлэн, нэг дугуй засах газар, мөн чөлөөт цагаа өнгөрөөх төв байдаг ба энэ төв нь оёдлын болон мужааны гэх мэт тасагтай.

Нэмэлт мэдээлэл

Хэрвээ та энэ мэдээллийн хуудсыг уншаад нэмж асуух асуулт гарвал Экваторлуу (0593) 53 58 42 гэсэн утсаар утасдан лавлаж болно.

GGZ Drenthe

De Evenaar (Экватор)

Altingerweg 1

9411 RA Beilen

Шуудангийн хайрцаг 30000

9410 RA Beilen

Утас (0593) 53 58 42

Факс (0593) 53 58 51

E-mail: deevenaar@ggzdrenthe.nl

Экватор нь Weijerd байранд байдаг. Анх ирж байгаа үйлчлүүлэгчид нь үүний хажууханд байгаа Etstoel байрны гол хаалгаар ороод нарийн бичгийн даргат бүртгүүлэх хэрэгтэй.

www.ggzdrenthe.nl

GGZ Drenthe юу хийдэг вэ?

GGZ Drenthe нь сэтгэц мэдрэлийн өвчтнийг эмнэлэгт хэвтүүлж юмуу эмнэлэгт хэвтүүлэхгүйгээр эмчлэх юмуу газар дээр нь эмчилгээ хийдэг. Энэ сэтгэл мэдрэлийн өвчнийг эмчлэх эрүүл мэндийн төв нь 3 хэсэгт хуваагдан ажилладаг: Хойд- Дрэнтэ, Зүүн урд Дрэнтэ мөн Баруун урд Дрэнтэ. Түүнээс гадна GGZ Drenthe нь шүүх шинжилгээний хүрээнд хэвтүүлэх юмуу газар дээр нь тусламж үзүүлдэг.

Өндөр настангуудыг асарч сувилахдаа хоёр асрамжийн газар болон хоёр сувилгааны газарт явуулдаг.

Урьдчилан сэргийлэх, иргэдэд эмчилгээ хийх мөн эрдэм шинжилгээний хүрээнд судалгаа явуулах, эдгээр зүйлүүд GGZ Drenthe-ийн гол ажиллагаа юм. GGZ Drenthe нь олон төрлийн сургалтуудыг явуулдагь жишээ нь сэтгэл мэдрэлийн эмч, эрүүл мэндийн сэтгэл зүйч, эмнэлгийн сэтгэл зүйч, сувилагч, асрагч гэх мэт.

GGZ Drenthe-д ойролцоогоор 3000 хүмүүс ажилладаг ба эдгээр нь Дрэнтэ мужид байдаг арав гаруй төвүүдэд ажилладаг. Жил болгон 15000 хүн бид нараас тусламж хүсэн ирдэг.

© 2006 GGZ Drenthe, Ассэн, НЛ

ZW.023P (11/06)

GGZ Drenthe нь энд бичигдсэн ба зурсан бүх зүйлд зохиолчийн эрхийг эдлэх ба энэ нь хуулийн дагуу хамгаалагдсан. GGZ Drenthe-еэс бичгээр, албан ёсны зөвшөөрөл авсаны дараа энд бичигдсэн зүйлийг хэсэгчлэн юмуу бүхлээр нь хувилж авч ашиглаж болно. Энэ талаар тодруулахыг хүсвэл Харьцаа Холбооны тасагтай холбоо барина уу.